

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2022 ОНЫ 5 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 1/363 дугаартай сургууль, цэцэрлэгийн анги танхим, зорчих хэсгийн талбай, хүүхдэд хамааралтай орчинд үзлэг, шалгалтыг хийж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг 05 дугаар сарын 18-ны өдөр хийж гүйцэтгэсэн.

2022 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлага, халалтын ажлыг аймгийн Засаг даргын А/..... дүгээр захирамж, сумын Засаг даргын А/41 тоот захирамжаар 4 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулагдаж 38 иргэн анхан шатны эрүүл мэндийн үзлэгт орж, 9 иргэн тэнцэж, үүнээс 3 иргэн хугацаат цэргийн албанд татагдсан байна.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын ажил төсөвт байгууллагуудад зохион байгуулагдаж байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/237 тоот захирамжийн хүрээнд хөдөө аж ахуйн хагас жилийн ээлжит тооллогын ажлын бэлтгэл ажил хангагдаж байна.

Сүхбаатар аймгийн “Төрийн албаны зөвлөл” суманд ажиллаж төрийн албан хаагчдын хувийн хэрэг бүрдүүлэлт, томилгоо, тушаал, захирамжид хяналт хийж, нийт төрийн албан хаагчид “Төрийн албан хаагчдын ёс зүй” сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 62 төрийн албан хаагч хамрагдлаа.

Бичиг үсгийн баярын өдрийг тохиолдуулан “МОНГОЛ БИЧИГ- БИДНИЙ БАХАРХАЛ” арга хэмжээг албан байгууллагуудын дунд зохион байгууллаа. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан хаагчдыг Монгол бичгээр алдаагүй, сайхан бичих, хурдан зөв унших үйл ажиллагааг зохион явууллаа.

“Түвшин манлай хурд” Сүхбаатар аймгийн баруун бүсийн аварга хүлэг шалгаруулах морин уралдаан 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдаж, 5 насны 250 орчим морь уралдаж, хүүхэд хамгааллын баг хурдан морь гарааны үед хамгаалалтын хувцас, хурдан морь унаач хүүхдийн даатгалыг шалгаж гаргасан ба ямар нэгэн зөрчил, хүүхэд бэртсэн тохиолдол гараагүй.

Аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар албан даалгаврын хүрээнд сар бүрийн 24-ний өдрийн дотор “Хариу арга хэмжээний тайлан”-г “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн.

2022-2023 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэн суралцах 6 настай нийт 83 хүүхдийн нэрчилсэн судалгааг сумын хэмжээнд нэгтэн гаргаад байна.

2022 оны 05 дугаар сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3432, өрх 986, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн 6, нас барсан 11 хүн бүртгэгдсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газраас сумын 2021 оны ОНХСангийн баримтад гүйцэтгэлийн аудит хийсэн.

Сар бүрийн 8-ны дотор шилэн дансанд байгууллагуудын сарын төсөв гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шивж байна.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төлөвлөгөөний дагуу 20,0 сая төгрөгний ногоон байгууламжийн хашаа хайс байгуулах, 20,0 сая төгрөгний мод бутны суулгац худалдан авах ажлууд хийгдээд байна.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан Нэг тэрбум мод үндэсний хөдөлгөөнд Түвшинширээ сум нэгдэж 5 сарын 23 ны байдлаар нийт сумын хэмжээнд 4029 ширхэг модыг тариад байна. Үүнд: Хайлаас-3685 ширхэг хайлаас, 188 агч, улиас-57, бургас-10, монос-4, үхрийн нүд-30 ширхгийг тус тус тариад байна. Байгууллагууд 3180, иргэд-849 мод тариад байна.

Мал төллөлт сумын хэмжээнд 68,8%, төл бойжилт 100% байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/242 тоот захирамж, сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/44 тоот захирамжийн дагуу Мөнххаан сумтай хиллэдэг Дэлгэрхаан, Үнэгд багийн үхэр сүргийг Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 2022 оны 05 дугаар сарын 10-ний өдрөөс 05 дугаар сарын 20-ыг хүртэлх хугацаанд 1 удаа хийж дуусгалаа.

Нийт 2570 толгой үхэр вакцинжуулалтад хамрагдахаас 2 багийн 71 хот айлын 2570 үхэр, бүгд 2570 толгой үхэр хамрагдаж, 100%-тай вакцинжуулалт хийгдсэн байна. Тарилгад 2600 тун вакцин зарцуулж, хэвийн хорогдолд 30 тун-г устгасан байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/172 тоот захирамж, сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/37 тоот захирамжийн дагуу сумын нийт үхэр сүргийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 05 дугаар сарын 08-ийг хүртэлх хугацаанд 1 удаа хийж дуусган дүн мэдээг нэгтгэн аймгийн МЭГ-т хүргүүлсэн.

Сумын хэмжээнд 5 багийн 582 хот айлын 18266 үхэр вакцинжуулалтад хамрагдахаас 18266 үхэр хамрагдаж, 100%-тай вакцинжуулалт хийгдсэн байна.

2023 оны вакцины захиалгыг хувийн хэвшлийн малын эмч нараас авч, захиалгыг нэгтгэн аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.

Одоогоор орон нутгийн өвчний 6 төрлийн вакцинжуулалт /галзуу, боом, дуут, шөвөг яр, листериоз, дотрын халдварт хордлого/ тус тус голомттой айл өрхүүдэд хийгдэж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д ажил хайгч 7 иргэний мэдээллийг бүртгэсэн.

2022 оны 05-р сард 2020-2021 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан хөтөлбөрт хамрагдсан 9 иргэн хуваарийн дагуу 1012500 төвлөрүүлэхээс 7 иргэн 712500 төгрөгийн ХЭДС-ийн 100120037010 тоот дансанд төвлөрүүлсэн.

"Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд малжуулах арга хэмжээний төслийг сумын хэмжээнд зарласан нийт 7 төсөл ирснээс 6 төслийг сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн сонгон шалгарууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан төсөл хөтөлбөрт "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-т 9 иргэн, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-т 5 иргэн, нийт 14 иргэн төсөл өгсөн.Эдгээр иргэдийн төслийн үнэлгээ хийж явуулсан.

2022 оны 05-р сарын 20-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих-2 иргэн, Ажлын байрыг дэмжих-6 нийт 8 иргэд аж ахуй эрхлэх цахим сургалтад хамруулсан.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-т 1 ахмад 5,0 сая төгрөгийн оёдлын төсөл шалгарч гэрээ, батлан даагчийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарь, нэхэмжлэх зэргийг бүрдүүлэн аймгийн ХХҮГ-т хүргүүлсэн.

2022 оны 05-р сарын 23-ны өдөр аймгийн ХХҮГ-аас зохион байгуулсан онлайн хуралд хамрагдсан.

Оролцоо төслийн бүртгэлд хамрагдах хүсэлтэй 18-34 насны залуучуудад зарыг өгч нийт 7 иргэн бүртгэсэн.

Ногоон ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлж хүнсний эрхийн бичгийн өрх болон ажилгүй 10 иргэнийг ажиллуулж байна.

Хүүхдийн мөнгөний хүсэлтээ бэлнээр авах хүсэлтээр 6 хүүхдийн ехаламж системд бүртгэсэн.

Нийгмийн халамжийн тэтгэврийн сунгалт 2 иргэнд, асаргааны тэтгэмж сунгалт-2 иргэнд, 534266 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган бэлтгэн өгч нөхөн олгуулсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний 5 дугаар сарын олголтыг гэрээт дэлгүүр Буянт супер маркет дэлгүүрээр 3 өрхөд олголтыг хийсэн. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ халамжаас хөдөлмөрт хүрээнд 3 өрхийн 1 өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулах шийдвэр гаргасан.

05-р сард Нийгмийн халамжийн ehalamj системд Нийгмийн халамжийн тэтгэврийн сунгалт 2 иргэн, асаргааны тэтгэмж 2 иргэнд, Цалинтай ээж хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 8 иргэнд, Жирэмсэн эхийн тэтгэмжид 6 иргэнд, нийт 18 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэвэр тэтгэмжид хамруулсан.

Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны дарга сумдуудад хуваарийн дагуу 5-р сарын 27-ны өдөр ирж ажиллахтай холбогдуулан сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэрийг баг багаар нь гаргаж багийн Засаг дарга нарт өгч зарыг хүргэж байна.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: ЕБС: Олон улсын эх дэлхийн өдрөөр "Автомашингүй өдөр" болгон зарлаж, тухайн өдрийн 8-8.30 цагт 30 минут

гэрэл цахилгаанаа унтраах, тухайн өдөр уурын зуухаа ажиллуулахгүй байх, байгаль эх дэлхийгээ хайрлаж сургуулийн орчинд ургаж байгаа мод бутыг сургуулийн ажилчидтай хэлбэржүүлж янзлах, ургалтыг сайжруулах ажлуудыг хийсэн.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн соёлыг хамтдаа хэвшүүлье” ХАБЭА аяны хүрээнд сургуулийн багш ажилчдын дунд Волейболын тэмцээн зохион байгууллаа. Тус аяны хүрээнд сургуулийн багш ажилчид “Ажлын байрны дасгал хөдөлгөөн”-ий уралдаан зарлаж тухайн дасгал хөдөлгөөнөө хамтаараа жигд хийж буй эсэхийг шалгарууллаа.

“Сурагч 7 хоног” аяныг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд сурагчдад чиглэсэн дараах үйл ажиллагааг төлөвлөж гүйцэтгэв.

Сурагчдад “Гоо зүйг боловсрол олгох, эрүүл зөв хооллолтын сургалтыг сургуулийн эмч, хоол зүйч нар хамтран зохион байгууллаа. Охид хөвгүүд гэртээ хийсэн хоолоороо бие биедээ туршлага солилцох “Хоолны өдөрлөг” зохион байгуулсан

Сурагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль дүрмийн сургалтын сумын хэсгийн төлөөлөгч зохион байгуулав. Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хамгаалах зорилготой “Шар дарцаг” аяны үйл ажиллагааг сурагчдад танилцууллаа.

“Хорт зуршаас хамтдаа сэргийлцгээе” нөлөөллийн сургалтыг охидын зөвлөлийн гишүүд зохион байгууллаа.

“Дотуур байр-Миний гэр орон” сургалтыг сургуулийн дотуур байрны сурагчдад Насан туршийн боловсролын багш зохион байгуулж дотуур байрны сурагчидтай ярилцлаа.

“Сурагч 1 өдөр” сургуулийн орчинд сурагчдын удирдлага зохион байгуулалтыг хийж мэргэжлийн багш, удирдлагуудын оронд сурагчдыг томилж тухайн сурагч оногдсон үүрэгт ажлаа тухайн өдөр орлон гүйцэтгэхээр зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд 7-11-р ангийн 50 сурагчид хамрагдлаа.

Сурагчдын хүсэл сонирхолд тулгуурлан “Энгийн хувцастай өдөр”-ийг зохион байгууллаа. Тухайн өдөр сурагчдын харилцаа хандлагад эерэг нөлөөлөх “Танилцах үдэшлэг” зохион байгуулав. Сурагчид 7 хоногийн хүрээнд Волейбол, даамны тэмцээн зохион байгууллаа.

Сургуулийн захирлын гаргасан шийдвэрийн дагуу сар бүрийн 10-ны Хүүхдээ сонсох өдөр, сар бүрийн 20-ныг “Эцэг эхээ сонсох” өдөр болгон шийдвэрлэсний хүрээнд 5-р сарын 10-нд сургуулийн сурагчдаа сонсох “Хүүхдээ сонсох өдөр” уулзалтыг зохион байгууллаа. Энэхүү уулзалтанд 60 гаруй сурагчид хамрагдлаа. Тухайн сурагчдад өмнөх уулзалтаар гаргасан санал шүүмжлэлийг хэрхэн шийдвэрлэсэн талаар танилцуулж санаа бодлыг нь сонслоо. Уулзалтын дараа сурагчдаас санал авахад 30 асуудлаар өөрсдийн саналаа илэрхийллээ.

5-р сарын 20-нд “Эцэг эхээ сонсох өдөр” өдөрлөгийн зохион байгуулав. Тухайн өдөрлөгийн хүрээнд дараах ажлуудыг удирдамжийн дагуу зохион байгууллаа.

МУ-ын ЗГ-аас хэрэгжүүлж байгаа “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аяныг танилцуулах “Эртэч эцэг эх-Эрүүл зөв дадал хэвшил” дасгал хөдөлгөөнийг 5-р сарын 20-ны өглөө 7 цагт эцэг эхчүүдтэй хамтарч хийлээ. Дасгал хөдөлгөөнд 90

шахам эцэг эх хамрагдлаа. “Өглөөний цайг-ӨӨРТӨӨ зориулъя” эцэг эх сургуулийн хамт олонтой цайлах, уулзалт ярилцлага хийлээ. Энэ үеэр “Зөв зохистой хооллолт” брошурыг танилцуулж эцэг эхчүүдэд тараалаа. Мөн хүүхэд хүмүүжлийн эерэг арга, Монгол ардын сурган хүмүүжүүлэх арга ухаан сургалт тус тус зохион байгууллаа.

2021-2022 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайлан, хичээл сургалтын тайлан, багшийн хөгжлийн тайлан, хүүхэд хамгааллын тайланг тус тус эцэг эхэд тайлагналаа.

Анхны жилдээ ажиллаж байгаа залуу багш нарын “Сургалтын хэрэглэгдэхүүний үзэсгэлэн”-г гаргаж эцэг эхэд толилуллаа.

Сургуулийн бага ангийн сурагчдад хэрэгжиж байгаа “Үдийн хоол” хөтөлбөр, дотуур байрын сурагчдын хоол хүнстэй танилцах үйл ажиллагааг эцэг эхийн дунд зохион байгууллаа.

“Хамтдаа хичээе-Хамтдаа зүтгэцгээе” анги бүлгийн эцэг эхчүүдийн Волейболын тэмцээнийг зохион байгууллаа.

Аймгийн Биеийн тамир спортын газрын мэргэжилтнүүд суманд ирж олимпизмийг сурталчлах зорилготой “Олимпын бамбар” залах ёслолыг сургуулийн спорт зааланд зохион байгуулж, спортын өндөр амжилт гаргасан сурагчид жагсаж хүндэтгэл үзүүллээ.

БШУЯамнаас зохион байгуулж байгаа сургуулийн багш нарын ажлыг үнэлж дүгнэх “Гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт”-ыг авч байна.

Сургууль цэцэрлэгийн залгамж холбоог сайжруулах хамтран ажиллах зорилгоор БЗАН, Цэцэрлэгийн ЗАН хамтран “6 настанг зугаатай сургая” хөтөлбөрт уламжлалт үйл ажиллагаагаа амжилттай зохион байгууллаа. Уг үйл ажиллагаагаар хэл яриа сургалтын чиглэлээр бага ,СӨБ ийн багш хамтын хичээл , бэлтгэл бүлгийн 2 багш хамтран ирэх намар сургуульд элсэн орох 88 хүүхдэдээ "Урилга"-аа гардууллаа.

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ: Дээд газраас ирж буй захирамж, тушаал шийдвэр, зөвлөмжийг мөрдөн, хугацаат болон хариутай бичиг, тоон мэдээг тогтмол цаг хугацаанд нь хүргэн, үүрэг чиглэлийн дагуу ажиллаж байна. Халаалт дулаан хэвийн, 7 хоногийн хүнсний нөөц, түлээ нүүрсний 5р сарын 15хүртэл нөөцтэй. 7хоногт 2 удаа их цэвэрлэгээ ариутгалыг тогтмол хийж, халдвар хамгааллын дэглэм баримтлан эрсдэлгүй орчин бүрдүүлэн ажиллаж байна.

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан “Монгол бичиг бидний бахархал” арга хэмжээнд байгууллагаараа амжилттай оролцож тэргүүн байрыг эзлэн шилжин явах цомын эзэд болж ирэх жилийн тэмцээнийг зохион байгуулах эрхийг авлаа.

“6 настанг зугаатай сургая” хөтөлбөрт өдөрлөгийг ЕБС-ийн багын ЗАН-тэй хамтран сургууль цэцэрлэгийн хамтын холбоог сайжруулах, бие биенээсээ суралцах зорилготой зохион байгуулж сургуульд элсэн суралцах 87 хүүхдэд урилгыг гардуулахын зэрэгцээ багш нарын хамтарсан хичээл, хэлэлцүүлэг хийлээ.

Эрт илрүүлгийн үзлэгийг эхлүүлж, одоогоор 15 хүүхдийг хамруулж “А” витаминг уулгаад байна.

Гепатитгүй монгол төслийн хүрээнд байгууллагын багш ажилчдын дунд судалгааг хийж 1,2-р тунд хамрагдаагүй 17 багш, ажилчдад 1,2-р тунг хийлээ.

“Бид Монголдоо хайртай” тайлант өдөрлөгийг зохион байгууллаа. Энэхүү тайлант өдөрлөгөө сургалтын 6 чиглэлээр зохион байгуулж хүүхэд бүрийн эзэмшсэн чадварыг харуулснаараа онцлог боллоо. Энэ үеэр багш хүүхдийн хамтарсан бүтээлийн үзэсгэлэнг гаргаж 6 чиглэлийн 5434 ширхэг сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материал, багш нарын бүтээлийг дэлгэж эцэг эхчүүдэд тайлагналаа.

Төлөвлөгөөт шалгалтыг 1 удаа хийсэн. Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ болон бүлгүүдийн цэвэрлэгээ үйлчилгээ, эрүүл ахуйд мөн хоол үйлдвэрлэл болон хүнсний хадгалалт хамгаалалт, татан авалтанд өдөр бүр хяналт тавьж байна. Тогооч нарыг өглөө бүр тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцуулан гарын үсгийг зуруулж хэвшээд байна.

Бүлгийн багш, туслах багш, тогооч, үйлчлэгч нарын өдөр тутмын ажлын хувцас өмсөж байгаа байдал, эрүүл ахуй, хувцасны шкафын эмх цэгцэд хяналт тавьж өдөр бүр тэмдэглэл хөтөлж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь арилгуулж ажиллаж байна.

“Аюулгүй ажиллагаа- Амьдралын баталгаа” гэсэн уриалгыг өглөө бүр хэрэгжүүлэх үүднээс тоног төхөөрөмж хариуцсан ажилтан болон бусад ажилчдын тоног төхөөрөмжтэй хэрхэн ажиллах талаар заавар зөвлөгөөг өглөө ажилдаа орохоос өмнө өгч гарын үсгээр баталгаажуулж хэвшлээ. Аюулгүй ажиллагааны 10 дүрэм, халтирч унахаас болгоомжил, ажиллаж буй тоног төхөөрөмжтэй болгоомжтой харьцана уу, гар хуруу зүсэх аюултай тул болгоомжтой харьцана уу гэх мэт 9 төрлийн санамжийг зохих хүмүүст өгч самбарт байршууллаа.

“Багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм” -ийг сар бүрийн 24-ны өдөр танилцуулж гарын үсэг авч баталгаажуулж ажиллаж байна. Үүний үр дүнд ёс зүйн зөрчил арилж хамт олны дунд халуун дулаан ур амьсгал бүрдэж байна. Энэ сарын 20ны өдөр нийт 27 багш, ажилчдад багш ажилчдын ёс зүйн дүрмийг танилцууллаа.

Сүхбаатар аймгийн “Төрийн албаны зөвлөл”-өөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын ёс зүй” сургалтанд хамрагдан, сургалтанд хамрагдаж чадаагүй байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад хуваалцах сургалт зохион байгууллаа.

Байгууллагын нийт багш ажилчдын ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, зөвлөгөө зөвлөмж, санамж өгч ажиллаж байгаа бөгөөд энэ сард 1 зөрчил гарсныг зөвлөлийн хурлаар хэлэлцээд байна.

Шүлгийн дугуйланг ахлах, бэлтгэл бүлгийн 15 хүүхдэд долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт хичээллэж байна.

Байгууллагын тайлант өдөрлөгт бэлдэж Д.Пүрэвдорж “Тусгаар тогтнол” шүлгийг хүүхдүүд эх орноо хайрлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх монгол хүн болж төрснөөрөө бахархах сэтгэгдэл төрүүлж зорилгоор массаар нь цээжлүүлэн бэлдэж байна.

Шүлгийн дугуйлан нь 2 сарын хугацаанд 4 шүлгийг массаар нь цээжлүүлээд байна.

Гар урлалын дугуйлан 12 хүүхдийн бүрэлдэхүүнтэй явагдаж байна.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Аймгийн Засаг даргын 2022оны А/139 дугаар захирамжийн дагуу аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан бүх нийтийн соёл урлагийн боловсролыг дээшлүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх, тодруулах зорилгоор сумдын дунд зохион байгуулж байгаа урлагийн наадамд ардын авьястанууд, СӨБ, ЕБС –ийн багш нар, ЭМТ, ЗДТГ –ын ажилтан албан хаагч нар болон нийт 40-өөд уран бүтээлчдийн бүрэлдэхүүнтэй амжилттай оролцлоо. Монгол ардын дуу “Талын таван толгой” Б. Даваасүрэн 1-р байр, Язгуур урлаг өв соёл “Адуучин эрийн магтаал” С. Гүндалай 1-р байр, Нутгийн зохиолчийн дуу, уран бүтээл “Магнаг цэнхэр дэлхий” 2-р байр, Хамтлаг бүжиг “Түүхэн тамга” СУГ –ын нэрэмжит шагнал тус тус хүртсэн.

Номын сан нь фондын 3000 гаруй номтой үйл ажиллагаагаа явуулж Байнгын уншигч-15, ирэгсэд-50, гэрээр 35 ном олгож ажиллалаа. 2022-оноос LiB4U шинэчилсэн программаар үйл ажиллагаагаа явуулах ба, энэхүү программыг хэрхэн ашиглах сургалтад хамрагдсан. Мөн номын сангийн дэргэдэх “Номын клуб” дугуйланд 14 сурагчдад номыг хайрлах хамгаалах, сэргээн сэлбэн засах зэрэг арга барилыг зааж сурган хүмүүжүүлж байна.

“Судар-Эгшиглэн” төсөлд оролцогчдын мэдээллийг нэгтгэн цахимаар сурталчилсан байна.

05 сарын 20-23-ны өдрүүдэд “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2022” арга хэмжээ МУ –ын ИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” уриатайгаар зохион байгуулагдлаа. Нийтээр тэмдэглэх баяр, болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа 2050” хөтөлбөр, мөн номын баярын ажлын хүрээнд төлөвлөгөө гарган дараах ажлуудыг зохион байгуулсан. ЕБС-ийн 5-8 дугаар ангийн дунд “Үлгэрийн баатрыг амилуулсан нь” дүрийн тоглолтыг зохион байгуулж 160 гаруй сурагчид оролцсоноос байр эзлүүлэн шагнаж урамшууллаа.

Соёлын төвийн орон нутаг судлах танхимын ажилтан нь ЕБС –ийн 5 -6-р ангийн 70 гаруй сурагчдад “Олон улсын музейн өдөр”-үүдээр “Орон нутаг судлах танхим” болон үйл ажиллагааг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, сум орон нутгийн үүсэл хөгжил, үл хөдлөх түүхэн дурсгал, засаг захиргааны нэгжийн талаарх мэдээ мэдээллийг хүргэн, өв соёлыг өвлөн уламжлах, бүтээлч сэтгэлгээтэй болгох, үндэсний хэл, ёс заншил, өв уламжлалаа эрхэмлэн дээдлэх зөв төлөвшил олгох зорилгоор сургалт зохион байгуулсан. Соёлын өвийн талаарх мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд Соёлын өвийн тухай хуулийг цувралаар танилцуулж байна.

Соёлын төв нь 5 дугаар сард Сүхбаатар-80 сумдын урлагийн наадамд Түвшинширээ сумын ардын авьяастнууд оролцсон “МАГНАГ ЦЭНХЭР ДЭЛХИЙ” тоглолт, нийтийн цэнгээнт бүжиг 2 удаа, МУГЖ Л. Бямбажав “Түмэнтэйгээ” аялан тоглолт, СӨБ –ийн сурагчдын “Бид Монголдоо хайртай” тайлант өдөрлөг, Сүхбаатар аймгийн баруун бүс “АВАРГА ХҮЛЭГ” хурдан морь шалгаруулах уралдааны нээлтийн болон тухайн өдрийн үйл ажиллагааг ЗДТГ, Түвшин манлай уяачдын холбоотой хамтран, аймгийн ахмадын хорооноос зохион байгуулж буй “Ахмадаа сонсьё” үйл ажиллагаанд сумын ахмадын холбоотой хамтран хурал, дуун цэнгүүн зэрэг арга хэмжээ тус тус зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2022оны А/233 дугаар захирамжийн биелэлтийг хангаж байгууллагын ажилтан албан хаагч нарт төрийн албан хаагчдын ёс зүйн сургалтыг зохион байгуулсан.

Мөн аймгийн Засаг даргын 2022 оны А/236 дугаар захирамжаар батлагдсан “Эрүүл мэндийнхээ төлөө - Алхангаа ярилцъя”, “Илүүдэл жингүй – Эртэч Монгол” аянуудын ажлын хүрээнд иргэдэд эрүүл идэвхтэй амьдралыг сурталчлан ажлын сондгой тоотой өдрүүдэд “ Эрүүл биед саруул ухаан оршино” уриатай дасгал хөдөлгөөн, заавал сурах 16 бүжгийг зааж бусад соёлын олон талт арга хэмжээг тус, тус зохион байгуулан ажиллаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 236, алсын дуудлага 7, гэрийн дуудлага 8, хэвтэн эмчлүүлэгч 19, Ковидын /Халдвартай бүс/ -д хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн байхгүй, Нас баралт 0.

Эрүүл мэндийн төв нь магадлан итгэмжлэлд орж 3 жилийн хугацаагаар магадлан итгэмжлэлээ аваад байна.

Мөн Сувилагч нарын баярыг тохиолдуулан сумын соёлын төвд нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, үзлэг шинжилгээ хийлээ.

5-р сард Ковидын 4-р тунгийн вакциныг 2 хүнд, товлохын вакциныг 46 хүүхдэд хийгээд байна. Элэг бүтэн монгол хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбоотой зорилтот насны иргэдийг шинжилгээнд хамруулах ажил явагдаж байна.

Тайлан нэгтгэсэн: ХЭЗХМэргэжилтэн Ш.Дүүрэнбилэг

Хянасан:Тамгын газрын дарга Ц.Ренчинмядаг